

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд иргэд, байгууллагаас Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, холбогдох санал бэлтгэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх Өргөдлийн байнгын хороог байгуулах, Аж үйлдвэржилтийн бодлогын болон Инновац, цахим бодлогын байнгын хороог Эдийн засгийн байнгын хороонд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд, Ёс зүй, дэгийн байнгын хороог Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус нэгтгэх, Байнгын хороодыг нэгтгэсэнтэй холбоотойгоор Аж үйлдвэржилтийн бодлогын, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, дэгийн, Инновац, цахим бодлогын байнгын хороодын эрхлэх асуудлыг холбогдох байнгын хороодод шилжүүлэх, Түүнчлэн Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд Ёс зүйн, Бүсчилсэн хөгжлийн; Эдийн засгийн байнгын хороонд Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн; Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, Хүнс, хөдөө аж ахуйн; Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд Шинжлэх ухааны, Соёл, спорт, залуучуудын дэд хороог байгуулах зохицуулалтыг тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Г.Уянгахишиг нар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд нэгтгэх үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир Улсын Их Хурлын одоогийн бүтэц болон Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороог бусад Байнгын хороонд нэгтгэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Улсын Их Хурлын тусгай хяналтын дэд хорооны тухай хуулийн төсөл болон хянан шалгах түр хорооны даргалагчтай холбоотой хуулийн төслүүдийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцийг өөрчлөх нь зохимжгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд Байнгын хороодод гишүүд хуваарилахдаа олонх, цөөнхийн төлөөллийг зохистой хуваарилах талаар, Улсын Их

Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Баярбаатар нар хуулийн төслийг дэмжиж байгаа боловч Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог татан буулгахыг дэмжихгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Байнгын хороодыг нэгтгэх, гишүүдийн тоог нэмэх нь хурлын ачаалал, ирц, асуудал хэлэлцэх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй талаар, мөн Байнгын хороодын статистик мэдээлэл, ачаалал зэрэг тодорхой судалгааг гаргах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд бүтцийн өөрчлөлтөөр гарах хэмнэлт, үр ашгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад тодорхой саналаа тусгаж, ажлын хэсэг байгуулан ажиллах талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 63.2 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 63.2 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Ж.БАТ-ЭРДЭНЭ